



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 361

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны "Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай" 318 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 64.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нэг нэрийн нийт 755,030,431 (долоон зуун тавин таван сая гучин мянга дөрвөн зуун гучин нэг) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг "Улаангомьн дулааны хоёрдугаар станц" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Х.Энхбат, "Улаангомьн дулааны хоёрдугаар станц" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Э.Баатарсан, "Ховд дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Д.Энхсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн  
 367 дугаар тогтоолын хавсралт

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНООС "УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ"  
 ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэс эн, ашиглалта д орсон он	Нэгж. Үнэ	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ
				Тоо	Дүн			
1	Утаа шүүх фильтерын цогц төхөөрөмж PPC96-3	1/1/2021	755,030,431	1	755,030,431	1.00	755,030,431	755,030,431
	Нийт дүн							
			(долоон зуун тавин таван сая гучин мянга дөрвөн зуун гучин нэг)		(долоон зуун тавин таван сая гучин мянга дөрвөн зуун гучин нэг)		(долоон зуун тавин таван сая гучин мянга дөрвөн зуун гучин нэг)	(долоон зуун тавин таван сая гучин мянга дөрвөн зуун гучин нэг)